



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 98

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын баталсан 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын албан хэрэгцээнд зориулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 899,600,000.00 (найман зуун ерэн есөн сая зургаан зуун мянган) төгрөгийн суудлын автомашин олж авахыг зөвшөөрч, автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Г.Баясгаланд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000195

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2019 оны 04 дүгээр сарын 02-ны
..... өдрийн 98... дугаар тогтоолын
хавсралт

**Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үндсэн хөрөнгө олж авах
хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр	хэм жих нэгж	тоо шир хэг	Анхны өртөг (төгрөгөөр)	Нийт үнэ (төгрөгөөр)
1	Суудлын хөдөлгүүрийн багтаамж 2000 сс	ш	2	80,800,000.00	161,600,000.00
2	Суудлын хөдөлгүүрийн багтаамж 4600 сс	ш	3	246,000,000.00	738,000,000.00
			5		899,600,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		5 (тав)		899,600,000.00 (найман зуун ерэн есөн сая зургаан зуун мянга)